



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/58

Сүхбаатар сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.16, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.3, 13.2.10 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих "Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Сүхбаатар сум"-ын ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга

Я.Мөрөн
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд

Л.Төгөлдөр
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн)

Б.Мөнхсоёл
(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)


Нарийн бичгийн

Дарга

Ж.Мөнхтуяа
(Сүхбаатар сумын иргэний төлөөлөл) тохиролцсоноор

Д.Октябрь
(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтын ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан, холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, явц үр дүнгийн талаар танилцуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Я.Мөрөн)-д даалгасугай.



Н.ЛХАГВАДОРЖ

C:\users\albanbichig\2021\zahiramj\A4.docx

430810145



1